



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б. БИЛЭГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-05 № 04/32 ЧАА-САТ/2013/201/САТ-ТТЗ
Зөрчлийг арилгуулах тухай

Цагдаагийн ерөнхий газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад дараахь зөрчил илэрлээ.

Цагдаагийн ерөнхий газрын Техник засварын төв нь 2012 онд Гэрээт албаны арилжааны банк болох Улаанбаатар банк дахь 2611008220 тоот харилцах дансанд Антбиг ХХК- р дамжуулан гэрээт ажил цуцлагдсан тул санхүүжилт буцаан шилжүүлэв гэж 2,1 тэрбум төгрөгийг оруулсан ба уг мөнгийг бэлнээр гаргуулан авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2011 оны дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журмын 2.9-д "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд бараа ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 200,0 мянган төгрөгөөс хэтрээгүй байна. Энэ тогтоосон хэмжээнээс хэтэрсэн болон байнга харилцан гүйлгээ хийдэг бол Төрийн сангийн бүртгэлийн дансаар дамжуулан төлбөр тооцоо хийнэ" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасан "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулахын тулд акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэсэн заалтыг үндэслэн дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг өгч байна.

Дээр дурдсан 2,1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилган, давтан гаргахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч биелэлтийг 2013 оны 10 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цагдаагийн ерөнхий газрын дарга Б.Билэгт, ерөнхий нягтлан бодогч Ш.Эрхэмбаяр нарт даалгав.

АУДИТОР Ш.ИЧИНХОРЛОО



УХА0122

07.1.17